

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/15-ШТА-НА

Чойбалсан хот 2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
Ерөнхий мэдээлэл.....	5
 БҮЛЭГ А. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ ОЛГОСОН БАЙНА.....	6
А.1 Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд батлагдсан төсвийг бүрэн хуваарилж олгосон байна.....	6
А.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумын Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.....	7
 БҮЛЭГ Б. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	7
Б.1 Аймгийн Сонгуулийн хороо батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна..	7
Б.2. Сумын Сонгуулийн хороодод хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	8
 БҮЛЭГ В. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВЬЖ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН БАЙНА.....	9
В.1 Аймаг, сумын сонгуулийн зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнасан байна....	9
В.2 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....	9-10
 ДҮГНЭЛТ:	10
АУДИТЫН ХЯЗГААРЛАЛТ.....	10
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
ШТА	Шууд тайлагналын аудит
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Батлагдсан төсөв, хуваарилагдаж ирсэн төсөв.	6
Хүснэгт 2	Сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.	7
Хүснэгт 3	Аймгийн Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.	8
Хүснэгт 4	Сумын Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.	9

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1¹-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д “Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана” гэж заасныг үндэслэн гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргахад зорилт чиглэгдлээ. Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: • <i>Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;</i> • <i>Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх;</i> • <i>Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх;</i>
Аудитын хамарсан хүрээ	Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аймгийн болон сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ганбилэг нар хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлүүлж, тайланг УАГ-ын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар болон аймгийн Сонгуулийн хороонд 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлээ.

¹ шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 63 дугаар тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны 2024 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “сумын Сонгуулийн хорооны бүрэлдэхүүн”-ийг байгуулан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт 819 албан хаагчид аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд 949.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Дорнод аймгийн хэмжээнд нийт 51,442 сонгогч саналаа өгөхөөс 30,531 буюу 59.35 хувийн ирцтэйгээр аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон байна.

БҮЛЭГ А. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ ОЛГОСОН БАЙНА.

А.1 Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд батлагдсан төсвийг бүрэн хуваарилж олгосон байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны А/68 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралтаар Дорнод аймгийн сонгуулийн хорооны төсвийг 949.3 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 1. Батлагдсан төсөв, хуваарилагдаж ирсэн төсөв.

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Хуваарилагдаж ирсэн төсөв	Зөрүү
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,097.5	1,097.5	-
2	Сонгуулийн байгууллагын ажилтан, сургалтын зардал	12,429.0	12,429.0	-
3	МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	17,044.0	17,044.0	-
4	Аймаг, сумын хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	12,100.0	12,100.0	-
5	Аймаг, сумын хэсгийн хорооны шуудан холбооны зардал	14,850.0	14,850.0	-
6	Аймаг, сумын хэсгийн хорооны унааны зардал	63,770.0	63,770.0	-
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	21,000.0	21,000.0	-
8	Сурталчилгааны зардал	20,000.0	20,000.0	-
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	1,820.0	1,820.0	-
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах,хүргэх ачаа, томилолтын зардал	42,484.0	42,484.0	-
11	Томилолтын зардал / Саналын хуудас аймагт СЕХ хүргэх зардал	13,632.0	13,632.0	-
12	Сүлжээний судалгаа хийх зардал	296.2	296.2	-
13	Саналын хуудас устгах зардал	3,000.0	3,000.0	-
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	6,160.0	6,160.0	-
15	Санал авах байрны түлээний зардал	6,600.0	6,600.0	-
16	Сурталчилгааны материал тараах зардал	10,500.0	10,500.0	-
17	Шуурхай багийн зардал	4,660.0	4,660.0	-
18	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал НДШ	609,498.4	609,498.4	-
19	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал НДШ	83,574.4	83,574.4	-
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх зардал	4,830.0	4,830.0	-
	Дүн	949,345.5	949,345.5	

Эх сурвалж: аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв, дансны хуулга.

Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн олгосон байна.

А.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумын Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3-т заасан зардлуудад төсөв хуваарилсан байна.

Хүснэгт 2. Сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.

/мянган төгрөгөөр/

д/д	Сумын нэр	Аймаг, сумдад хуваарилсан төсөв	Аудитаар тооцсон төсөв	Зөрүү
1	Баяндун	41,858.2	41,858.2	-
2	Баянтүмэн	39,619.0	39,619.0	-
3	Баян-Уул	55,317.0	55,317.0	-
4	Булган	40,504.0	40,504.0	-
5	Гурванзагал	37,131.6	37,131.6	-
6	Дашбалбар	56,151.0	56,151.0	-
7	Матад	56,162.0	56,162.0	-
8	Сэргэлэн	55,081.0	55,081.0	-
9	Халхгол	40,723.0	40,723.0	-
10	Хөлөнбуйр	37,203.6	37,203.6	-
11	Цагаан-овоо	64,823.2	64,823.2	-
12	Чойбалсан	46,435.8	46,435.8	-
13	Чулуунхороот	38,051.6	38,051.6	-
14	Хэрлэн	166,452.6	166,452.6	-
	дүн	775,513.6	775,513.6	-
1	Аймаг	173,831.9	173,831.9	-
	Нийт дүн	949,345.5	949,345.5	-

Эх сурвалж: аймаг, сумын Сонгуулийн хорооны төсвийн хуваарь.

Аудитаар аймаг, сумын төсвийн хуваарилалтыг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу давтан тооцож үзэхэд зөрүү гараагүй.

БҮЛЭГ Б. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Б.1 Аймгийн Сонгуулийн хороо батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын 2024 оны 3/777, 3/834, 3/852, 3/893 3/909 3/940 тоот албан бичгээр ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарт заасны дагуу аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 3. Аймгийн Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.

		/мянган төгрөгөөр/		
д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,097.5	1,097.5	-
2	Сонгуулийн байгууллагын ажилтан, сургалтын зардал	6,219.0	6,219.0	-
3	МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	7,379.0	7,379.0	-
4	Аймаг, сумын хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	1,000.0	1,000.0	-
5	Аймаг, сумын хэсгийн хорооны шуудан холбооны зардал	1,500.0	1,500.0	-
6	Аймаг, сумын хэсгийн хорооны унааны зардал	47,151.8	47,151.8	-
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	18,750.0	18,750.0	-
8	Сурталчилгааны зардал	20,000.0	20,000.0	-
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	1,820.0	1,820.0	-
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах,хүргэх ачаа, томилолтын зардал	20,804.0	20,804.0	-
11	Томилолтын зардал / Саналын хуудас аймагт СЕХ хүргэх зардал	6,532.0	6,532.0	-
12	Сүлжээний судалгаа хийх зардал	296.2	296.2	-
13	Саналын хуудас устгах зардал	3,000.0	3,000.0	-
14	Сурталчилгааны материал тараах зардал	7,070.0	7,070.0	-
15	Шуурхай багийн зардал	4,660.0	4,660.0	-
16	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал НДШ	12,549.6	11,937.4	612.2
17	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал НДШ	9,172.8	9,172.8	-
18	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх зардал	4,830.0	4,830.0	-
	дүн	173,831.9	173,219.7	612.2

Эх сурвалж: аймгийн Сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь батлагдсан төсвөөс 173.2 сая төгрөгийг зарцуулж 0.6 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлжээ. Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн тайлан, дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгахад хууль, журмын дагуу зарцуулсан байна.

Б.2. Сумын Сонгуулийн хороодод хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Сумын Сонгуулийн хороод нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 4. сумын Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.

д/д	Сумын нэр	Төсөв	/мянган төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Баяндун	41,858.2	41,858.2	-
2	Баянтүмэн	39,619.0	39,619.0	-
3	Баян-Уул	55,317.0	55,317.0	-
4	Булган	40,504.0	40,504.0	-
5	Гурванзагал	37,131.6	37,131.6	-
6	Дашбалбар	56,151.0	56,151.0	-
7	Матад	56,162.0	56,162.0	-
8	Сэргэлэн	55,081.0	55,081.0	-
9	Халхгол	40,723.0	40,723.0	-
10	Хөлөнбуйр	37,203.6	37,203.6	-
11	Цагаан-овоо	64,823.2	64,823.2	-
12	Чойбалсан	46,435.8	46,435.8	-
13	Чулуунхороот	38,051.6	38,051.6	-
14	Хэрлэн	166,452.6	166,452.6	-
дүн		775,513.6	775,513.6	-

Эх сурвалж: сумын Сонгуулийн хороодын төсвийн гүйцэтгэл

Сумын Сонгуулийн хороод нь батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан байна. Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн тайлан, дансны хуулга, анхан шатны баримтуудтай тулган шалгахад хууль, журмын дагуу зарцуулсан байна.

БҮЛЭГ В. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВЬЖ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН БАЙНА.

В.1 Аймаг, сумын сонгуулийн зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнасан байна.

Аймаг, сумын Сонгуулийн хороод нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтаар сонгуулийн зардлын тайлангаа гаргасан байна.

Аудитаар зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэхийг эдийн засгийн ангиллаар тулган шалгахад зөрүү гараагүй.

В.2 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны 8 дугаар сарны 19-ний өдрийн 3/777 дугаартай албан бичгээр Дорнод аймгийн Сонгуулийн хороодын дансны жагсаалтыг хүргүүлсэн байна. Сонгуулийн хороодын зардлын гүйлгээнд аймаг, сумын төрийн сангаас хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч Ц.Амгаланзаяа нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-д заасан санхүү, эдийн засгийн бакалавр, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, санхүүгийн тайлан гаргах чадвартай байх гэсэн шалгуурыг хангасан байна.

Сонгуулийн хорооны дарга сонгуулийн хорооны зардлын гүйлгээний баримт дээр нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг зурж ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, гүйцэтгэлд зөвлөмж, чиглэлийг өгч, хяналт тавьж ажилласан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс батлагдсан зардлыг хууль, журмын дагуу хуваарилж олгосон байна.
2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.
3. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлын зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнасан байна.

АУДИТЫН ХЯЗГААРЛАЛТ:

Аудитын тайлангийн хугацааны хязгаарлалт. Үүнд:

Дорнод аймгийн Сонгуулийн хорооноос аймаг, сумын Сонгуулийн хороодын зардлын тайлан, холбогдох баримт материалыг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн №08 тоот албан бичгээр Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Төрийн аудитын байгууллагад Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан санал авах өдрөөс хойш 27 хоногийн дараа аймаг, сумын Сонгуулийн хороодын зардлын тайлан, холбогдох баримт материалыг ирүүлсэн талаар аймгийн Сонгуулийн хорооноос тодруулахад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал хураалтын дүнгээр 2 хэсэгт санал тэнцэж дахин санал авах ажил зохион байгуулагдсан тул санхүүгийн тайланг нэгтгэх хугацаа хойшлогдсон гэсэн тайлбарыг өгсөн.

ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 4/18

Чойбалсан хот

Г


Тайлан баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Дорнод аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзий нарт хүргүүлсүгэй.



011010192

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN